

## ЧЭМААБО –НЫ БОДЛОГО

Аплас + нь өөрсдийн сорилт, шалгалт, баталгаажуулалт, инженеринг болон үнэлгээ хийх техникийн ур чадвараа хүнд үйлдвэрлэл болон хэрэглээний бүтээгдэхүүн, машин механизм, үйлчилгээ болон аливаа байгууламжийн инноваци, хөгжүүлэлт, чанар, байнгын сайжруулалт болон аюулгүй ажиллагаанд хөгжүүлэн, ажиллана. Үүний зэрэгцээ бид бизнесийн зорилгоо хадгалж, хэрэглэгч, хөрөнгө оруулагчдынхаа болоод компанийн бүх гишүүд талуудын сэтгэл ханамжийг дээшлүүлэхийг зорин ажиллаж байна. Үүний нэгэн адил, бид сонирхогч талууддаа өгсөн үүрэг амлалтаа биелүүлэхийн зорьж байна.

Чанар, эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалтын болон байгаль орчны үйл явцыг холбогдох хууль эрх зүй, зохицуулалт болон хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаандаа мөрдөж үүднээс чанарын шаардлагыг хангахад чиглүүлэн ажиллахыг чухалчлан авч үзнэ.

Бид байнгын сайжруулалтыг үргэлжлүүлэн хийх үүрэг амлалтаа жилийн зорилго, зорилтуудаар дамжуулан хэрэгжүүлж, ЧЭМААБО-ийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх, хянах замаар менежментийг амжилттай хэрэгжүүлнэ. Эдгээр зорилтууд нь байгууллагын орчинтой уялдаж, сонирхогч талуудын зүгээс тавьсан зорилт, үр дүн, нийцтэй байдлыг хангуулахад чиглэсэн байх бөгөөд энэ нь үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, ажилтнуудын чадавхийг хөгжүүлэх зэрэг байгууллагын гол хэсгүүдэд чиглэх бөгөөд ингэснээр бид үйлчлүүлэгчдэдээ илүү сайн үйлчилгээ үзүүлэх чадна. Түүнчлэн энэхүү бодлого нь ажиллагсдын ур чадвар, хэрэглэгчийн сэтгэл ханамж зэрэгтээ анхаарах боломжийг бүрдүүлж, хэрэглэгчиддээ үзүүлэх бизнесийн үйлчилгээний түвшинг илүү өндөр түвшинд хүргэхэд дэмжлэг үзүүлэх юм.

- Энэхүү бодлогын үндсэн зарчим нь дараахь шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэн, найдвартай, тогтвортой орчныг тасралтгүй сайжруулалтыг хангахад чиглэнэ.
- Тогтвортой ашиг, орлогыг бий бологоход суурилсан тогтвортой нэмүү өртгийг бий болгоход чиглэснээр алдаа дутагдал, хоцролтоос үүдэлтэй өртөгөөс зайлсхийх боломжийг бүрдүүлнэ.
- **ЧЭМААБО –ны** системчилсэн хандлага нь орон нутгийн мөрдвөл зохих хууль тогтоомжийн нийцлийг хангах төдийгүй тухайлсан ажил үйлчилгээ хийхтэй холбоотой бусад нэмэлт шаардлагуудыг баталгаажуулахад оршино.
- Ажил мэргэжлийн холбоотой аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, эдийн засаг, техникийн, хууль эрхзүйн болон нийгмийн асуудлууд, байгаль орчныг хамгаалах асуудлыг хамарсан ЭМААБО-ны удирдлагын тогтолцоог боловсруулж, хэрэгжүүлэх нь компанийн дотоод менежментийн үр нөлөө, давуу талыг бий болгоно.
- Тогтолцооны эдгээр шаардлагууд нь компанийн удирдамж, олон улсын шалгуур үзүүлэлт дээр суурилсан байх бөгөөд манай компани нь ЧХС-ийн тогтолцооны менежмент, гүйцэтгэлд тасралтгүй сайжруулах явдал ордог.
- Мэргэжлийн үйл ажиллагааны бүхий л үе шатуудад үнэнч шударга байдал, нууцлалыг хадгалах, Ёс зүйн дүрэмд тусгасан бие даасан байдал, компанийн үнэт зүйлсийн талаархи зарчмуудыг баримтлан ажиллана.
- Ажиллагсад төдийгүй, гэрээт гүйцэтгэгчид төдийгү сонирхогч талуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах байгууллагын өмнө хүлээсэн үүргийн хүрээнд зохих төлөвлөлт, харилцаа холбоог батжуулан, түүгээр дамжуулан ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ үйл явцыг хөгжүүлэх явцад гарсан асуудлын мөрөөр залруулах ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэн урьдчилан сэргийлэх арга замыг тэргүүн чиглэлээ болгон ажиллана. Үүнд хяналтын арга хэмжээнүүдийн шаталбарыг ашиглан холбогдох эрсдэл, аюулыг тогтмол хянаж, багасгах зэрэг үйл ажиллагаа багтана.
- Нийт ажиллагсаддаа манлайлал, үүрэг амлалтаа биелүүлэн ажиллах нь хамт ажиллагсад болон компанийн бүх түвшинд ажилчдын оролцоог нэмэгдүүлж, байгууллагаараа бахархан хамтран ажиллах нөхцлийг улам идэвхижүүлнэ. Ажиллагсдын өөрт байгаа ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн хувийн амьдрал болоод ажил байдлыг хослуульж чадахуйц уур амьсгалыг бий болгох.
- Нийгэм соёлын хөгжилд түлхэц үзүүлэх, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, боолчлол, хүний наймааны эсрэг нийгмийн санал санаачлагуудыг дэмжих.
- Дэвшилтэт техник технологийн хэрэглээг урамшуулах, тасралтгүй сайжруулалтыг хангах замаар шинэ техник технологийг үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллах.
- Энэхүү баримт бичгийг Applus + Energy & Industry IMS-ийн сайтын Applus + Portal-ийн HSQE хэсэгт шууд авч үзсэн тохиолдолд "хяналттай" гэж үзэх бөгөөд татаж авсан буюу хэвлэсэн хуулбарыг "хяналтгүй" гэж үзнэ. Ингэснээр баримт бичгийн хяналтын хүрээнд хуучин эх үүсвэрийг ашиглахгүй байх явдлыг хангах юм.
- Судалгаа болон хөгжүүлэлтийн үйл ажиллагааг оролцуулан шинэ санаачлагыг дэмжих, харилцан сонирхсон төслүүдийн талаар бусад байгууллагуудтай хамтран ажиллах, мэдлэг солилцох явдлыг байнга дэмжих.
- Харилцагч, ханган нийлүүлэгчдийн хүлээлтэнд хүрэхэд дэмжлэг үзүүлэхүйц байгууллагын үйл ажиллагаа, бүтэц зохион байгууллагын нэгтгэлийг тэдгээртэй хамтран ажиллахдаа хамтын ажиллагааны итгэлцэл, шударга, илэн далангүй, харилцан хүндэтгэлийг тэргүүн чиглэл болгоно.



- Компанийн амжилт, ирээдүйн төлөвлөгөөг нийтэд үнэн зөв, нээлттэй мэдээллэх.
- Applus + группийн бүх гишүүд нь энэхүү бодлогын нийцтэй байдалд дүн шинжилгээ хийж, бүх сонирхогч талуудад зориулсан, баримтжуулсан системээр хэрэгжих бөгөөд тэдгээр нь хамааралтай, тохиромжтой байгаа эсэхийг үечилсэн байдлаар хянаж үзнэ.



FERNANDEZ  
ARMAS  
RAMON -  
32795345J

**Ramon Fernandez Armas**  
Executive Vice-President of Applus+ Energy & Industry Division  
Date: